



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/154

Арвайхээр

Г

Журам батлах тухай

1

Эрүүл мэндийн тухай 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/263 дугаартай “Алсын дуудлага, явуулын эмнэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/294 дугаартай “Журам батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаартай “Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягыг шинэчлэн батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаартай “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/220 дугаартай “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” тушаал, Америкийн зүрх судасны нийгэмлэгийн “Амилуулах лавшруулсан тусламж үзүүлэх 2016, 2020” удирдамж, Монгол улсын стандарт “Түргэн тусламжийн бүтэц үйл ажиллагаа” MNS 6717:2018 стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгооны эмчилгээний төвөөс харъяалалын аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн алсын дуудлагын дагуу төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлэх “Алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.“Алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй, цаг алдахгүй хүргэж байхаар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа), Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр), Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч (Э.Мөнхцэцэг), Зөвлөх эмч нар, Эм зүйн албаны дарга (Ц.Мөнгөнтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй, цаг алдахгүй хүргэж ажиллахыг Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга (Д.Аззаяа), Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин) нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ

Г.ДАШЖАНЦАН